



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/04/НА/СТА-ААТҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах Аудитор Д.Цэрэнханд Утас: 99147999 Цахим хаяг: tserenkhanded@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	9
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	
3.8 Аудитын гол асуудал	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНАБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>256,014,779.38</u>	<u>212,509,568.47</u>
33	АВЛАГА	221,611,934.17	157,226,524.77
335	Бусад авлага	221,611,934.17	132,596,139.77
3351	Байгууллагаас авах авлага	171,317,142.17	47,367,046.77
3352	Хувь хүмүүсээс авах авлага	50,294,792.00	85,229,093.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,969,837.46	34,464,540.46
351	Түүхий эд материал	2,186.46	2,186.46
35110	Тусгай зориулалттай материал	2,186.46	2,186.46
35300	Бэлэн бүтээгдэхүүн	26,319,677.00	31,347,380.00
354	Хангамжийн материал	6,647,974.00	3,114,974.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,995,000.00	1,035,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,652,974.00	2,079,974.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,679,287,193.15</u>	<u>5,961,295,007.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,679,287,193.15	5,961,295,007.03
392	Биет хөрөнгө	5,652,701,315.75	5,937,761,181.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,520,743,795.65	9,064,521,450.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,528,083,103.20)	(3,758,385,496.05)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	745,833,138.66	745,833,138.66
39204	Хуримтлагдсан элэгдэл	(206,723,660.58)	(240,254,629.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	292,534,286.38	297,486,195.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(179,098,788.54)	(182,913,637.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,513,692.20	25,016,342.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,804,207.32)	(20,870,799.90)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,063,700.00	11,900,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,277,537.50)	(4,572,082.30)
393	Биет бус хөрөнгө	26,585,877.40	23,533,826.00
39301	Програм хангамж	2,738,669.60	2,488,944.80
39303	Бусад биет бус хөрөнгө	23,847,207.80	21,044,881.20
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,935,301,972.53</u>	<u>6,173,804,575.50</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,791,288,289.40</u>	<u>4,800,415,891.50</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	79,817,111.67	105,958,403.77

**Говь-Алтай аймгийн "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

413	Өглөг	79,817,111.67	105,958,403.77
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	240,770.00	335,047.00
4136	Бусад өглөг	79,576,341.67	105,623,356.77
41361	Байгууллагад төлөх өглөг	52,463,255.00	105,623,356.77
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	9,115,361.00	
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	17,971,643.87	
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	26,081.80	
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,711,471,177.73	4,694,457,487.73
422	Урт хугацаат зээл	4,711,471,177.73	4,694,457,487.73
4222	Гадаад валют	4,711,471,177.73	4,694,457,487.73
42230	Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	4,711,471,177.73	4,694,457,487.73
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,144,013,683.13	1,373,388,684.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,144,013,683.13	1,373,388,684.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,635,440,432.78	3,181,198,087.78
51101	Өмч: - төрийн	2,635,440,432.78	3,181,198,087.78
512	Хуримтлагдсан үр дүн	(1,551,187,164.62)	(1,867,569,818.75)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,551,187,164.62)	(1,867,569,818.75)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	59,760,414.97	59,760,414.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,935,301,972.53	6,173,804,575.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,072,135,902.70	1,087,580,985.24
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,072,135,902.70	1,087,580,985.24
110	Орлогын албан татвар	1,072,135,902.70	1,087,580,985.24
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,072,135,902.70	1,087,580,985.24
110002	Үйл ажиллагааны орлого	1,072,135,902.70	1,087,580,985.24
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,300,583,285.84	1,403,963,639.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,300,583,285.84	1,403,963,639.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,300,583,285.84	1,403,963,639.37
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,300,583,285.84	1,403,963,639.37
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	833,189,641.20	952,879,083.63
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	344,312,474.64	382,491,821.93
210813	Бусад зардал /ТӨҮГ/	123,081,170.00	68,592,733.81

**Говь-Алтай аймгийн "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(228,447,383.14)	(316,382,654.13)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(228,447,383.14)	(316,382,654.13)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан


Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,399,161,670.56	59,760,414.97	-1,322,739,781.48	1,136,182,304.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,399,161,670.56	59,760,414.97	-1,322,739,781.48	1,136,182,304.05
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	236,278,762.22			236,278,762.22
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-228,447,383.14	-228,447,383.14
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,635,440,432.78	59,760,414.97	-1,551,187,164.62	1,144,013,683.13
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,635,440,432.78	59,760,414.97	-1,551,187,164.62	1,144,013,683.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,635,440,432.78	59,760,414.97	-1,551,187,164.62	1,144,013,683.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	545,757,655.00	0.00	0.00	545,757,655.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-316,382,654.13	-316,382,654.13
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,181,198,087.78	59,760,414.97	-1,867,569,818.75	1,373,388,684.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
-----	----------	----------	------------

**Говь-Алтай аймгийн "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,140,951,848.54	1,337,759,702.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,140,951,848.54	1,337,759,702.25
120	Нийтлэг татварын бус орлого	1,140,951,848.54	1,337,759,702.25
120009	Бусад орлого	0.00	1,468,245.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	1,140,951,848.54	1,336,291,457.25
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,128,376,140.10	1,322,537,207.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,128,376,140.10	1,322,537,207.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,128,376,140.10	1,322,537,207.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,763,027.00	488,102,909.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	402,763,027.00	488,102,909.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,056,826.20	156,780,770.80
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	137,056,826.20	156,780,770.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	137,164,300.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	0.00	137,164,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	350,355,804.00	177,178,113.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	0.00	116,804,183.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	350,355,804.00	60,373,930.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	238,200,482.90	363,311,114.46
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	0.00	599,178.08
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	130,027,537.14	179,778,652.51
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0.00	4,872,378.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	108,172,945.76	178,060,905.87
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,575,708.44	15,222,494.99
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	30,000,000.00
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	0.00	30,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,999,600.00	25,837,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,999,600.00	25,837,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,999,600.00	25,837,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,999,600.00	25,837,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,999,600.00	4,163,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-15,887,024.79	19,385,494.99
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,320,032.54	1,433,007.75
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,433,007.75	20,818,502.74



2.5 Аудит хийсэн үйлдвэр, санхүүжилтийн тайлан, гүйцэтгэл

Үзүүлэлт	Тайлант оны		Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Үйл ажиллагааны орлого	1,166,640,814.0	1,087,580,985.24	79,059,828.8	93%
Түрээсийн орлого			-	#DIV/0!
ОРЛОГО	1,166,640,814.0	1,087,580,985.2	79,059,828.8	
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			-	#DIV/0!
1.3 Нийт ашиг	1,166,640,814.00	1,087,580,985.24	79,059,828.76	93%
Үндсэн үйл ажиллагаа				#DIV/0!
Цалин	625,074,780.0	589,628,832.00	35,445,948.0	94%
Байгууллага төлөх НДШ	88,943,793.2	85,275,850.00	3,667,943.2	96%
Бичиг хэрэг	7,678,500.0	4,739,545.00	2,938,955.0	62%
Шуудан холбоо	9,138,000.0	7,762,132.00	1,375,868.0	85%
Сургалтын төлбөр	4,500,000.0	1,553,000.00	2,947,000.0	35%
Томилолт			-	#DIV/0!
Хөдөлмөр хамгаалал	37,163,000.0	11,169,504.00	25,993,496.0	30%
Шатахуун	63,228,000.0	60,157,127.00	3,070,873.0	95%
Түрээсийн төлбөр			-	#DIV/0!
Зээл, хүүгийн төлбөр	20,640,000.0		20,640,000.0	0%
Газрын төлбөр			-	#DIV/0!
Цахилгааны төлбөр	118,263,600.0	126,834,996.00	(8,571,396.0)	107%
Халаалтын төлбөр	46,825,680.0	39,557,336.00	7,268,344.0	84%
Зар сурталчилгааны зардал	2,437,200.0		2,437,200.0	0%
Гадны үйлчилгээний хөлс	21,764,000.0	4,684,710.00	17,079,290.0	22%
Гамшгийн зардал	5,000,000.0	3,690,419.50	1,309,580.5	74%
Засварын зардал	87,874,000.0	99,079,246.00	(11,205,246.0)	113%
Элэгдэл хорогдлын зардал	260,000,000.0	289,586,841.12	(29,586,841.1)	111%
Ажилчдын нийгмийн зардал	18,921,818.0	26,431,900.00	(7,510,082.0)	140%
Татвар даатгалын зардал	9,255,006.8	15,614,915.00	(6,359,908.2)	169%
Өвөлжилтийн бэлтгэл ажил	33,790,000.0	33,790,000.00	-	100%
банкны шимтгэл			-	#DIV/0!
Бусад	5,980,000.0	4,407,188.00	1,572,812.0	74%
1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	1,466,477,378.00	1,403,963,541.62	62,513,836.38	96%
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	299,836,564.00	316,382,556.38	16,545,992.38	106%
3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	299,836,564.00	316,382,556.38	16,545,992.38	106%
Татвараас чөлөөлөгдөх зардал				
Татвар төлөх ашиг алдагдал	299,836,564.00	316,382,556.38	16,545,992.38	1.06
3.1 Орлогын татварын зардал			-	
4. Татварын дараах ашиг алдагдал	299,836,564.00	316,382,556.38	16,545,992.38	1.06



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 40 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ “Эрүүл ахуйн стандартад нийцсэн ундны усаар хүн амыг хангаж, иргэн бүрт сэтгэл ханамжтай үйлчилгээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэхэд оршино” эрхэм зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.


Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч өөрчлөлт шинэчлэлийг хийгээгүй байна. Тус байгууллагад мөрдөж байгаа НББ-ын бодлогын баримт бичиг нь 2010 онд боловсруулагдсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 467.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардал 1,335.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 26.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 21.4 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга Байгууллагын үйл ажиллагаа

Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын зорилго нь “Эрүүл ахуйн стандартад нийцсэн ундны усаар хүн амыг хангаж, иргэн бүрт сэтгэл ханамжтай үйлчилгээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэхэд” оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “холбогдох хууль, тогтоомж болон тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүргийн хэмжээнд болон газрын үйл ажиллагааны чиглэл тус бүрээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж, стандартын шаардлага хангасан цэвэр усаар байнга тасралтгүй, найдвартай хангаж, бохир усыг татан зайлуулах” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчийн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 10 дугаар сарын 12-ны 77 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Мөн 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор газрын дүрэм, бүтэц орон тоо, цалингийн жишгийг шинэчлэн баталсан байна. Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12-т “орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэн эрхийг орон нутагт тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал хэрэгжүүлэхээр заасан.

Иймд Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн эрхийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хэрэгжүүлж байгаа бөгөөд цалин, урамшуулал олгоогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Аймгийн

Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт “орон нутгийн өмчит газруудын орлого нэмэгдүүлж, зардлыг бууруулж, төлөвлөгөөг батлуулан, өмч эзэмшлийн гэрээ байгуулах” талаар тусгасан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол батлагдахаас өмнө буюу 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр тус газрын бүтэц зохион байгуулалтыг өөрчилсөн байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтэц өөрчлөөгүй, орон тоог 4-өөр дутуу ажилласан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон боловч, ажиллагсад ойн шагнал олгосон, сурталчилгааны зардал гаргасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,433.0	20,818.5	+19,385.5
БХХО			
Авлага	221,611.9	157,226.5	-64,385.4
Урьдчилгаа			
Бараа материал	32,969.8	34,464.5	+1,494.7
Үндсэн хөрөнгө	5,679,287.2	5,961,295.0	+282,007.8
Биет бус хөрөнгө	9,347.8	6,295.5	3,052.3
Нийт хөрөнгийн дүн	5,935,301.9	6,173,804.6	+238,502.7
Өр төлбөрийн дүн	4,791,288.3	4,800,415.9	+9,127.6
Богино хугацаат өглөг	79,817.1	105,958.4	+26,141.3
Урт хугацаат өглөг	4,711,471.2	4,694,487.7	-16,983.5
Эздийн өмч	1,144,013.7	1,373,388.7	+100,667.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,935,301.9	6,173,804.6	+238,502.7

Касс дахь бэлэн мөнгөний эхний үлдэгдэлд 0.04 сая төгрөг болон бөгөөд 0.242 сая төгрөгийн мөнгө орж эцсийн үлдэгдэл 0.279 сая төгрөг байна.

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 20.5 сая төгрөг байгаагаас хаан банкны харилцах дансанд 20.4 сая төгрөг, Төрийн банкны харилцах дансанд 0.1 сая төгрөг, Хас банкны харилцах дансанд 0.04 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд НӨАТ-ын авлага 24.6 сая төгрөг, ААНБ, айл өрхөөс авах усны авлага 132.9 сая төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд төрөөс усны төлбөрийг хөнгөлсөнтэй холбоотойгоор НӨАТ-ын татварын илүү төлж, авлага үүсчээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 156.1 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 1.1 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлага нь өмнөх оны усны төлбөрийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 34.5 сая төгрөг болж 1.5 сая төгрөгөөр өссөн нь худалдаж авсан бараа материал нэмэгдсэнтэй холбоотой.

Тайлант онд худалдан авалтаар 54.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 53.1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үүнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 545.7 сая төгрөгийн Солонго хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээний ажил хийгдсэн, 4 худагт 20.0 сая төгрөгийн усны сав, 5.4 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авснаар нийт 571.6 сая төгрөгөөр нэмэгдэж, Аймгийн ИТХ-ын 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор 19.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийг акталсан байна.

Биет бус хөрөнгө 3.0 сая сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийг өөр байгууллага ашиглаагүй байгаа нь санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангаж байна.

Дуусаагүй барилга дансанд үлдэгдэлгүй байна.

Бусад эргэлийн бус хөрөнгөнд 17.2 сая төгрөгийн газрыг бүртгэсэн. Тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 105.9 сая төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөр дансанд 4,694.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь 2013 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн Мон-1847, Мон-2301 төслүүдийн зээлийн үлдэгдэл байна.

Богино хугацаат өр төлбөрийн 30.0 сая төгрөг нь тайлант хугацаанд арилжааны банкнаас авсан зээл, 46.2 сая төгрөг нь усны төлбөрийн илүү төлөлт, 29.4 сая төгрөг нь он дамжсан 2 байгууллагад төлөх өглөг байна.

Шалгагдагч байгууллага Азийн хөгжлийн банкнаас Мон-1847 төслийг 2013 онд 255.0 сая төгрөгийн зээлийг авч, зээлийг зориулалтын дагуу шугам сүлжээ шинээр тавихад зарцуулсан ба зээлийн эргэн төлөлт 187.0 сая төгрөг, зээлийн үлдэгдэл 68.0 сая төгрөг байна. Уг зээл нь 2025 онд дуусахаар байна.

Мөн Азийн хөгжлийн банкнаас авсан Мон-2301 төслийн зээл 4,694.5 сая төгрөгөөс зээлийн эргэн төлөлт огт хийгдээгүй байна.

Урт хугацаат өр төлбөр төлөгдөхгүй байгаа нь төлөх эх үүсвэр байхгүйгээс шалтгаалсан, үр дагавартай байна.

Шалгагдагч байгууллагын НБББББ-т зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг өртгийн зарчим баримтлан худалдан авах үеийн өртгөөр хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал, орлогын албан татварын зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 35.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг нэмэгдсэнтэй холбоотой.



Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт үйлдвэрлэл үйлчилгээний шууд ба шууд бус зардал, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал, бусад зардлуудыг хамруулсан байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 48 дугаар тогтоолоор Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,166.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,466.5 сая төгрөгөөр, 299.8 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 30.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 2021 оны 06 дугаар сард баталсан нь өмнөх хагас жилд төлөвлөгөө, зорилт хүрэх түвшин тодорхой бус ажилласан байна.

Гүйцэтгэлээр 1,087.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,403.9 сая төгрөгийн зардал гарган, 316.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,087.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 79.0 сая төгрөг буюу 7 хувиар тасарсан нь Засгийн газраас айл өрх, албан байгууллагын усны төлбөрийг төрөөс хөнгөлсөнтэй холбоотой 11, 12 дугаар сарын усны төлбөр орж ирээгүй зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,403.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 62.5 сая төгрөг буюу 4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Цалин НДШ, бичиг хэрэг хөдөлмөр хамгаалал, шуудан холбоо, гадны үйлчилгээний хөлс, бусад зардлыг хэмнэж зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 1 ажилд Есөнбулаг сумын ЗДТГ-ын эх үүсвэрээс 20.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 316.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 16.5 сая төгрөгөөр илүү байгаа нь орлогын төлөвлөгөө тасарсан шалтгаан нөлөөлж байна.

Тайлант онд 1,387.5 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 25.4 сая төгрөг үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба төсвөөс гадуур зардал гараагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хууль, ТБОНАБАҮХАТХуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 1,564.9 сая төгрөгийн 103 мэдээллээс 26.1 сая төгрөгийн 2 мэдээллийг мэдээлээгүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 0.5 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлснийг аудитын явцад нөхөн шивүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28.2, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т заасан заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.3 ТБОНӨХБАҮХАТХуулийн хэрэгжилт

Худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр 66.3 сая төгрөгийн шатахуун, 74.9 сая төгрөгийн сэлбэг, засварын материал худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайланд онд тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 42.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжүүлж ажилласан боловч худалдан авах ажиллагаа зарлаагүй зөрчлийг дахин давтан гаргасан байна. Удирдлага нягтлан бодогч нь солигдсон тул хариуцлага тооцох боломжгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөний биелэлт, шатахуун, сэлбэг хэрэгслийн худалдан авалт, төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллаж байгаа эсэх, бараа материалын тайлангийн тулгалт, НБББББ-д өөрчлөлт оруулсан эсэх зэргийг шалгах нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 394.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 55.7 сая төгрөгийн алдааг залруулж, 25.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 312.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайланд 25.5 сая төгрөгийн зарлагыг, 29.7 сая төгрөгийн орлогыг зөрүүтэй тайлагнасан

Тайлант хугацаанд 0.6 сая төгрөгийн И баримтгүй худалдан авалт хийснийг аудитын явцад нөхөн шивүүлсэн.



4.2.2 Төлбөрийн акт

Ажиллагсдад ойн баяраар 4.6 сая төгрөгийн шагнал олгосон нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т " төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Засгийн газраас усны төлбөрийг хөнгөлсөнтэй холбоотойгоор 20.9 сая төгрөгийн усны төлбөрийг сумуудтай тооцоо нийлээгүй, сумдын ЗДТГ авлагаар тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.2.3 Албан шаардлага

Засгийн газраас усны төлбөрийг хөнгөлсөнтэй холбоотойгоор 13.9 сая төгрөгийн усны төлбөрийг сумдын ус түгээдэг хүмүүстэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, 11, 12 дугаар сарын тайланг ирүүлээгүй байгаа нь Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр 0.7 сая төгрөгийн сурталчилгааны зардал гаргасан, батлагдсан төсвийн 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" 1.7-д "хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр 66.3 сая төгрөгийн шатахуун, 74.9 сая төгрөгийн сэлбэг, засварын материал худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

НӨАТ-ын тайланд орлогыг 18.7 сая төгрөгөөр илүү тайлагнаж, 1.8 сая төгрөгийн НӨАТ-ын авлагыг илүү тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой

удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Он дамжсан 29.4 сая төгрөгийн өглөг, 1.1 сая төгрөгийн авлагатай байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Татварын тайлангаар 12.0 сая төгрөгийн илүү төлөлттэй, 47.8 сая төгрөгийн татварын өглөг Шүүхийн шатанд маргаантай байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Орлогын төлөвлөгөө 79.0 сая төгрөгөөр тасарсан, алдагдлын түвшинг батлагдсанаас 16.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Захирал нь үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх өөрийн хөрөнгийн хэмжээ санхүүгийн тайлангаас 2,098.3 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй", Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам"-ын 8 дугаар зүйлийн 8.2-т "Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ", 8.2.3-т "хувь нийлүүлсэн хөрөнгө" гэсэн заалттай нийцэхгүй байна" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.2.4 Зөвлөмж

Аудитаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 19 дугаар тогтоолын хавсралт "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын дүрэм, бүтэц орон тоо, цалингийн жишгийг батлах тухай", Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Аймгийн Засаг даргад

1. Үр дүнгийн гэрээний биелэлт

1.1 Илрүүлэлт: "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын захиралтай байгуулсан гэрээг дүгнэж ажиллаагүй байна.

1.1 Өгсөн зөвлөмж: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 19 дугаар тогтоолын хавсралт "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм"-ийн 7.1-т "Аймгийн Засаг Дарга нь Үйлдвэрийн газрын гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан, жил бүрийн эцэст дүгнэж, цаашид хэрхэн ажиллах тухай саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах

"Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын захиралд

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайланд онд мэдээлбэл зохих 1,564.9 сая төгрөгийн 103 мэдээллээс 26.1 сая төгрөгийн 2 мэдээллийг мэдээлээгүй байна

1.1 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг хэрэгжүүлж ажиллах

2. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинэчлэгдсэн стандарт, хуулийн шаардлага хангахгүй, шинэчлэн батлуулаагүй байна.

2.1 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах"-ыг хэрэгжүүлэн, бодлогын баримт бичгийг стандарт хууль, журамд нийцүүлэн шинэчлэн батлуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	"Ундарга-Алтай" ОНӨААТҮГ	13	252.1	1	55.2	2	25.4	8	171.5	2	
Дүн		13	252.1	1	55.2	2	25.4	8	171.5	2	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	"Ундарга-Алтай" ОНӨААТҮГ	3	141.9	1	0.6			1	141.3	1	
Дүн		3	141.9	1	0.6			1	141.3	1	
Нийт дүн		16	394.0	2	55.8	2	25.4	9	312.8	3	

